

2024.10.23

**ГҮН ӨРМИЙН ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ, ХУУЧИН ХУДАГТ ЗАСВАР ХИЙХ
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

➤ **ШИНЭ ХУДАГ ГАРГАХ**

Цооног өрөмдөх, цооноглох тоноглох

- Шинэ худгийн цэг тогтоох хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай албан ёсны гэрээ байгуулсан байх, хэрэв өрөмдлөгийн компани өөрсдөө энэ ажлыг гүйцэтгэх бол зөвшөөрөлтэй байх бөгөөд эрсдэлийг хариуцаж, ямар арга хэрэглэх тухай танилцуулга ирүүлнэ.
- Худгийн цооног өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгохдоо MNS 6088:2010 стандартыг баримтална.
- Цооногийн ашиглалтын ундарга: 2м^3 /цаг- 6м^3 / цаг ус өгөх хүчин чадалтай байна.
- Суултын болон шүүр яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
- Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO гэрчилгээтэй байна.
- Ус өргөх яндан болон холбогч хэрэгсэл /муфит, угольник, тройник, винтель гэх мэт/ нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байна. /диаметр нь 25 мм-ээс багагүй байна./
- Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс томгүй байна.
- Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй
- Худгийг шавхалт хийж цэвэрлэх: Хугацаа 24 цагаас багагүй
- Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх
- Худгийг түр хугацааны тагаар тоноглох

Худгийн барилга, усан сан, мал услах онгоц, талбай барих

➤ Худгийн барилга

- ✓ Хэмжээ /дотор талдаа/: 3х3м, ханын өндөр шалнаас дээш 2м
- ✓ Материал: блок
- ✓ Ханын зузаан: 20 см-ээс багагүй
- ✓ Ханыг дотор, гадна талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна.
- ✓ Худгийн дээр 30х30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ
- ✓ Худгийн цонх нь 40х50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана./
- ✓ Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах
- ✓ Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох
- ✓ 40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
- ✓ Усан сан нь босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан $1,5\text{м}^3$ –ээс багагүй багтаамжтай, ган усан сан нь дээгүүрээ модон тагтай

➤ Мал услах онгоцны:

- ✓ Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр
- ✓ Материал: ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон
- ✓ Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна.
- ✓ Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ.
- ✓ Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гаргана.
- ✓ Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.

➤ Мал услах талбай:

- ✓ Хэмжээ: Нийт уртын дагуу 2 талдаа 2м-ийн өргөнтэй, зузаан нь 10 см

- ✓ **Материал:** 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө.
- ✓ **Услах талбай** нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.

Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар

➤ Гүний насос:

- ✓ **Техникийн модел**
- ✓ **Гарал үүсэл**
- ✓ **Үйлдвэрлэгчийн нэр, хаяг**
- ✓ **Үйлдвэрлэсэн он:** 2024 оноос хойш
- ✓ **Усны шахуургын гол эд анги, ажлын дугуй нь ширэм, гууль /латуны/ ган материалаар хийгдсэн байна.**
- ✓ **Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийг ашиглалтанд орсноос эхлэн 1 жилээс доошгүй баталгаат хугацаа өгнө. ISO гэрчилгээтэй байна.**
- ✓ **Албан ёсны үйлдвэрлэгчээс борлуулах эрхтэй компаниас худалдан авна. Баталгаат хугацаанд техникийн засвар үйлчилгээг бараа нийлүүлэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.**
- ✓ **Усны шахуурга нь усны орчны хасах 35 хэмээс нэмэх 35 хэм**
- ✓ **Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компанийн хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар /Монгол хэл дээр/ бэлтгэсэн байна.**
- ✓ **Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийн түргэн элэгддэг эд ангийн сэлбэг тус бүр 2 ширхэгийг дагалдуулна.**
- ✓ **Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.**
- ✓ **Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортай, насос ажиллуулах асаагууртай**
- ✓ **Цахилгаан үүсгүүр: Бензинээр ажилладаг, хасах 45 хэмээс нэмэх 45 хэмд ажиллах чадвартай байна.**

Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх

- Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаяг гэх мэт/
- Худаг, гүний насос, цахилгаан үүсгүүр ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх
- Худгийн паспортыг бэлтгэх

2. ХУУЧИН ХУДАГ ЗАСВАРЛАХ

- Гүний насос, цахилгаан үүсгүүр
- Худгийн цооногын лайг цэвэрлэх
- Худгийн цооног, дээд хэсэгт 100см х150см х80 харьцаатай байгууламж барих